



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуут сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/139/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.23 № 150
танай _____ -ны № _____ -т

ЧУЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.МӨНХБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуут сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуут сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,522,125.85	111,701,683.00
2	АВЛАГА	132,124.85	19,051,676.00
3	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	132,124.85	0.00
4	Бусад авлага	0.00	19,051,676.00
5	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	19,051,676.00
6	БАРАА МАТЕРИАЛ	30,390,001.00	61,249,007.00
7	Түүхий эд материал	0.00	4,053,000.00
8	Тусгай зориулалттай материал	0.00	4,053,000.00
9	Хангамжийн материал	30,390,001.00	57,196,007.00
10	Бичиг хэргийн материал	435,000.00	1,190,000.00
11	Аж ахуйн материал	28,335,001.00	54,929,007.00
12	Түлш, шатах тослох материал	1,620,000.00	1,077,000.00
13	НӨӨЦИЙН БАРАА	5,000,000.00	31,401,000.00
14	Тэжээлийн нөөц	5,000,000.00	31,401,000.00
15	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,029,838,374.14	997,580,446.71
16	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,029,838,374.14	997,580,446.71
17	Биет хөрөнгө	1,024,661,707.50	994,220,446.71
18	Барилга, байгууламж, орон сууц	476,655,054.76	586,537,040.76
19	Хуримтлагдсан элэгдэл	-102,254,489.91	-191,097,076.71
20	Авто-тээврийн хэрэгсэл	90,082,509.64	112,682,509.64
21	Хуримтлагдсан элэгдэл	-25,002,957.84	-43,669,090.88
22	Машин тоног төхөөрөмж(компьютер)	46,564,082.56	61,055,182.56
23	Хуримтлагдсан элэгдэл	-19,546,486.55	-23,763,134.14
24	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,484,948.00	19,864,000.00
25	Хуримтлагдсан элэгдэл	-20,803,496.54	-7,421,482.87
26	Зам, гүүрийн байгууламж	49,000,000.00	49,000,000.00
27	Хуримтлагдсан элэгдэл	-21,216,666.33	-27,541,666.17
28	Бусад үндсэн хөрөнгө	887,117,475.00	815,425,843.00
29	Хуримтлагдсан элэгдэл	-370,418,265.29	-356,851,678.48
30	Биет бус хөрөнгө	5,176,666.64	3,360,000.00
31	Програм хангамж	5,450,000.00	5,450,000.00
32	Хуримтлагдсан элэгдэл	-3,633,333.36	-5,450,000.00
33	Бусад биет бус хөрөнгө	3,360,000.00	3,360,000.00
34	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,065,360,499.99	1,109,282,129.71
35	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,065,360,499.99	1,109,282,129.71
36	Засгийн газрын хувь оролцоо	1,065,360,499.99	1,109,282,129.71
37	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	614,282,352.17	614,282,352.17
38	Хуримтлагдсан үр дүн	373,736,866.85	417,658,496.57
39	Өмнөх үеийн үр дүн	606,735,599.32	373,736,866.85
40	Тайлант үеийн үр дүн	-232,998,732.47	43,921,629.72
41	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
42	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	77,341,280.97	77,341,280.97
43	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,065,360,499.99	1,109,282,129.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	636,559,285.00	604,363,138.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	189,187,890.00	113,940,754.00
3	Нийтлэг татварын бус орлого	189,187,890.00	113,940,754.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	189,187,890.00	55,285,254.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,362,000.00	190,000.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	187,825,890.00	55,095,254.00
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	20,000,000.00
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	38,655,500.00
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,371,395.00	490,422,384.00
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,266,995.00	55,999,184.00
11	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	15,058,000.00
12	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,266,995.00	40,941,184.00
13	Орон нутгийн төсвөөс санхүүжих	415,104,400.00	434,423,200.00
14	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	415,104,400.00	434,423,200.00
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	551,686,467.91	560,441,508.28
16	УРСГАЛ ЗАРДАЛ	551,686,467.91	560,441,508.28
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,354,616.33	559,871,508.28
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,352,463.00	215,604,624.00
19	Үндсэн цалин	231,236,463.00	215,604,624.00
20	Урамшуулал	116,000.00	0.00
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,047,212.15	31,424,824.85
22	Тэтгэврийн даатгал	20,211,250.40	22,734,207.08
23	Тэтгэмжийн даатгал	2,315,794.16	2,068,141.33
24	ҮОМШӨ-ний даатгал	1,852,635.33	1,763,512.69
25	Ажилгүйдлийн даатгал	424,321.12	441,697.15
26	Эрүүл мэндийн даатгал	4,243,211.14	4,417,266.60
27	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,671,748.42	23,869,000.00
28	Гэрэл, цахилгаан	3,796,608.42	7,000,000.00
29	Түлш, халаалт	12,875,140.00	15,669,000.00
30	Цэвэр, бохир ус	0.00	1,200,000.00
31	Хангамж, бараа материалын зардал	57,446,340.00	63,109,770.00
32	Бичиг хэрэг	9,209,100.00	8,106,250.00
33	Тээвэр, шатахуун	26,365,940.00	28,308,120.00

Чулуут сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,009,600.00	4,259,000.00
35	Ном, хэвлэл	140,000.00	500,000.00
36	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,554,700.00	7,277,500.00
37	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,167,000.00	14,658,900.00
38	Нормативт зардал	3,869,800.00	6,921,050.00
39	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
40	Хоол, хүнс	669,800.00	6,921,050.00
41	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,200,000.00	0.00
42	Эд хогшил, урсгал засварын зардал	6,569,400.00	15,212,494.00
43	Багаж, техник, хэрэгсэл	1,134,400.00	100,000.00
44	Урсгал засвар	5,435,000.00	15,112,494.00
45	Томилолт, зочны зардал	687,500.00	1,000,000.00
46	Дотоод албан томилолт	687,500.00	1,000,000.00
47	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,074,813.00	22,886,864.00
48	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,254,813.00	21,386,864.00
49	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
50	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	500,000.00
51	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	0.00
52	Бараа үйлчилгээний бусад зардал	142,635,339.76	179,842,881.43
53	Бараа үйлчилгээний бусад зардал	22,765,042.00	47,950,700.00
54	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,472,000.00	150,000.00
55	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,398,297.76	131,742,181.43
56	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,331,851.58	570,000.00
57	Бусад урсгал шилжүүлэг	47,398,000.00	500,000.00
58	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,398,000.00	0.00
59	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	500,000.00
60	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,933,851.58	70,000.00
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,933,851.58	70,000.00
62	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	84,872,817.09	43,921,629.72
63	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	317,871,549.56	0.00
64	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	317,871,549.56	0.00
65	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-232,998,732.47	43,921,629.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	614,282,352.17	77,341,280.97	373,736,866.85	1,065,360,499.99
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	614,282,352.17	77,341,280.97	373,736,866.85	1,065,360,499.99
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	43,921,629.72	43,921,629.72
4	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	614,282,352.17	77,341,280.97	417,658,496.57	1,109,282,129.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	448,733,395.00	490,612,384.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,362,000.00	190,000.00
3	Нийтлэг татварын бус орлого	1,362,000.00	190,000.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,362,000.00	190,000.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,362,000.00	190,000.00
6	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	446,368,395.00	466,223,384.00
7	УРСГАЛ ЗАРДАЛ	446,368,395.00	466,223,384.00
8	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,036,543.42	465,653,384.00
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,557,200.00	234,316,300.00
10	Үндсэн цалин	229,441,200.00	234,316,300.00
11	Урамшуулал	116,000.00	0.00
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,974,600.00	31,632,700.00
13	Тэтгэврийн даатгал	21,796,900.00	22,260,100.00
14	Тэтгэмжийн даатгал	2,294,500.00	2,343,200.00
15	ҮОМШӨ-ний даатгал	1,835,500.00	1,874,500.00
16	Ажилгүйдлийн даатгал	458,900.00	468,600.00
17	Эрүүл мэндийн даатгал	4,588,800.00	4,686,300.00
18	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,291,748.42	23,000,000.00
19	Гэрэл, цахилгаан	3,796,608.42	7,000,000.00
20	Түлш, халаалт	13,495,140.00	14,800,000.00
21	Цэвэр, бохир ус	0.00	1,200,000.00
22	Хангамж, бараа материалын зардал	57,584,782.00	49,532,670.00
23	Бичиг хэрэг	8,600,500.00	8,711,250.00
24	Тээвэр, шатахуун	25,601,640.00	20,028,920.00
25	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,009,600.00	4,004,000.00
26	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,473,042.00	7,277,500.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,400,000.00	9,011,000.00
29	Нормативт зардал	3,200,000.00	5,471,250.00
30	Хоол, хүнс	0.00	5,471,250.00
31	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,200,000.00	0.00
32	Эд хогшил, урсгал засварын зардал	6,569,400.00	30,910,600.00
33	Багаж, техник, хэрэгсэл	1,134,400.00	100,000.00
34	Урсгал засвар	5,435,000.00	30,810,600.00
35	Томиллолт, зочны зардал	687,500.00	1,000,000.00
36	Дотоод албан томиллолт	687,500.00	1,000,000.00

37	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,410,813.00	24,081,864.00
38	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,410,813.00	22,581,864.00
39	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
40	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	500,000.00
41	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	0.00
42	Бараа үйлчилгээний бусад зардал	35,760,500.00	65,708,000.00
43	Бараа үйлчилгээний бусад зардал	30,860,500.00	65,558,000.00
44	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,900,000.00	150,000.00
45	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,331,851.58	570,000.00
46	Бусад урсгал шилжүүлэг	47,398,000.00	500,000.00
47	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,398,000.00	0.00
48	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	500,000.00
49	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,933,851.58	70,000.00
50	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,933,851.58	70,000.00
51	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,365,000.00	24,389,000.00
52	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,365,000.00	24,389,000.00
53	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,365,000.00	24,389,000.00
54	Дотоод эх үүсвэрээр	2,365,000.00	24,389,000.00
55	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,365,000.00	24,389,000.00
56	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,365,000.00	-24,389,000.00
57	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
58	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
59	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	434,543,200.00	434,543,200.00	0.00	100.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	434,543,200.00	434,543,200.00	0.00	100.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,043,200.00	434,043,200.00	0.00	100.00
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,316,300.00	234,316,300.00	0.00	100.00
5	Үндсэн цалин	234,316,300.00	234,316,300.00	0.00	100.00
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,632,700.00	31,632,700.00	0.00	100.00
7	Тэтгэврийн даатгал	22,260,100.00	22,260,100.00	0.00	100.00
8	Тэтгэмжийн даатгал	2,343,200.00	2,343,200.00	0.00	100.00
9	ҮОМШӨ-ний даатгал	1,874,500.00	1,874,500.00	0.00	100.00
10	Ажилгүйдлийн даатгал	468,600.00	468,600.00	0.00	100.00
11	Эрүүл мэндийн даатгал	4,686,300.00	4,686,300.00	0.00	100.00
12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,000,000.00	23,000,000.00	0.00	100.00
13	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
14	Түлш, халаалт	14,800,000.00	14,800,000.00	0.00	100.00
15	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00

Чулуут сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

16	Хангамж, бараа материалын зардал	43,933,600.00	43,933,600.00	0.00	100.00
17	Бичиг хэрэг	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.00
18	Тээвэр, шатахуун	18,169,600.00	18,169,600.00	0.00	100.00
19	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,664,000.00	3,664,000.00	0.00	100.00
20	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	0.00	100.00
21	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.00
22	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,800,000.00	9,800,000.00	0.00	100.00
23	Эд хогшил, урсгал засварын зардал	54,510,600.00	54,510,600.00	0.00	100.00
24	Багаж, техник, хэрэгсэл	23,700,000.00	23,700,000.00	0.00	100.00
25	Урсгал засвар	30,810,600.00	30,810,600.00	0.00	100.00
26	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
27	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
28	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.00
29	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
30	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
31	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	500,000.00	0.00	100.00
32	Бараа үйлчилгээний бусад зардал	39,150,000.00	39,150,000.00	0.00	100.00
33	Бараа үйлчилгээний бусад зардал	39,000,000.00	39,000,000.00	0.00	100.00
34	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	150,000.00	0.00	100.00
35	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	0.00	100.00
36	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	0.00	100.00
37	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00
38	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	434,543,200.00	434,543,200.00	0.00	100.00
39	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	387,090,300.00	387,090,300.00	0.00	100.00
40	Орон нутгийн төсвөөс	387,090,300.00	387,090,300.00	0.00	100.00
41	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,452,900.00	47,262,900.00	190,000.00	99.60
42	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.00	190,000.00	-70,000.00	158.33
43	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	47,332,900.00	47,262,900.00	70,000.00	99.85
44	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	51.00	51.00	0.00	100.00
45	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
46	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
47	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	0.00	100.00
48	Удирдах ажилтан	7.00	7.00	0.00	100.00
49	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
50	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00

51	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	0.00	100.00
52	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	0.00	100.00
53	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00	0.00	100.00
54	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,999,184.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	55,999,184.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,999,184.00
4	Хангамж, бараа материалын зардал	6,388,070.00
5	Бичиг хэрэг	711,250.00
6	Тээвэр, шатахуун	1,859,320.00
7	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	340,000.00
8	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,477,500.00
9	Нормативт зардал	5,471,250.00
10	Хоол, хүнс	5,471,250.00
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,581,864.00
12	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,581,864.00
13	Бараа үйлчилгээний бусад зардал	26,558,000.00
14	Бараа үйлчилгээний бусад зардал	26,558,000.00
15	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,999,184.00
16	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,999,184.00
17	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,058,000.00
18	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,941,184.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Чулуут сумын ЗДТГ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Чулуут сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 2/34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чулуут сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах”, 67.1.2-д “Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах”, 67.1.3-д “Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Төрийн байгууллага болон төрийн албан хаагчдыг манлайлах үр чадвартай, иргэдэд шуурхай үйлчилдэг цомхон чадварлаг төрийн алба бүрдүүлж, хөгжлийн үзүүлэлтээрээ аймгийн зүүн бүсийн сумдын төв болох”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чулуут сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 434.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 44.0 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Авлага	0.1	19.1	19.0	19000.0
Бараа материал	35.4	92.6	57.2	161.6
Үндсэн хөрөнгө	1,029.8	997.6	(32.2)	-3.1
Нийт хөрөнгө	1,065.3	1,109.3	44.0	4.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,065.3	1,109.3	44.0	4.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,065.3	1,109.3	44.0	4.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 19.0 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын данс нь 0.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлага 19.0 сая төгрөгөөр өсч 19.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Бараа материалын үлдэгдэл 57.2 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын данс нь 35.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 158.1 сая төгрөг, хандиваар буюу үнэ төлбөргүй хүлээн авсан 38.6 сая төгрөг нийт 196.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 139.5 сая төгрөгийн зарцуулалт гарч, 92.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тухайн жилд бараа материалын үлдэгдэл эрс өссөн нь өвс тэжээлийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3.1 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,029.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 24.4 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 185.0 сая төгрөг нийт 209.4 сая төгрөгөөр нэмэгдэж, аклан шилжүүлсэн 109.9 сая төгрөг, тайлант онд байгуулсан 131.7 сая төгрөгийн элэгдэл нийт 280.4 сая төгрөгөөр буурч оны эцэст 997.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 44.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт

Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	415.1	434.4	19.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	32.3	56	23.7
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	187.8		-187.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	75.1	75.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	38.7	38.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1.4	0.2	-1.2
Үйл ажиллагааны орлого	636.6	604.4	-32.2
Цалин, шимтгэлийн зардал	260.3	247	-13.3
Бусад бараа үйлчилгээний зардал	237.1	312.8	75.7
Урсгал шилжүүлэг	54.3	0.6	-53.7
Үйл ажиллагааны зардал	551.7	560.4	8.7
Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/	317.9		-317.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(233.0)	44.0	277.0

Чулуут сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 19.3 сая төгрөгөөр өссөн, нэмэлт санхүүжилтийн орлого 23.7 сая төгрөгөөр өссөн тайлант онд ковид-19 цар тахлын үед халдвар хамгаалалын түвшинд зарцуулалт гарсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 487.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 124.5 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 362.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 19.7 хувиар буюу 71.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь ковид 19 цар тахал, өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 434.5 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 434.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 55.9 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 21.7 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар ковид 19 цар тахлын тусгаарлах байрны хоол, хүнс, шатахуун, бусад зардалд, мөн цэрэг татлагын шатахуун, өвөлжилтийн бэлтгэл ажилд тус тус зарцуулсан байна.

- Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод зориулж 1.0 сая төгрөг, Ар-Ус Ундарга ХХК-аас усны төлбөрт 16.1 сая төгрөг, ГБХЗГ-аас 0.5 сая төгрөг, нийт 17.1 сая төгрөгийн санхүүжилтийг сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой 17.1 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын захирамжийн дагуу тусгаарлах байрны хоол, хүнс, аж ахуйн материал болон шатахууны зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангах зорилгоор сумын Засаг даргын нөөц сангаас 15.0 сая төгрөгийн 1100 боодол, аймгийн Засаг даргаас 9.5 сая төгрөгийн 633 боодол, сумын ОНХСагийн хөрөнгөөр 16.8 сая төгрөгийн 1245 боодол, нийт 41.3 сая төгрөгийн 2978 боодол өвс бэлтгэсэн байна.

Тус сумын сумын хэмжээнд 2021 оны 2021 оны 12 дугаар сарын 03-наас гоц халдварт буюу шүлхий өвчин гарч 2280 толгой мал өвчилсөн байна.

Мөн сумын ТЕЗахирагчийн буруутай шийдвэрийн улмаас ажлаас халагдсан нэг албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин шимтгэлийг байгууллагаас төлсөн 19.1 сая төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна. Үүнийг тухайн байгууллагыг төлөөлөн Тамгын газрын дарга анхан шатны шүүхэд нэхэмжлэл өгч шүүхээс буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар гаргуулан ЗДТГазрын дансанд төвлөрүүлэх шийдвэрийг 2021.01.27 өдөр гаргасан байна. Мөн энэ асуудлыг шийдвэрлүүлэх талаар аймгийн Төсвийн еөрнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт аудитын албанд 2021.07.19-ний өдрийн 01/513 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 85.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 434.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан аваагүй байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тайлант онд 2012 онд үйлдвэрлэгдсэн 20.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий 1 автомашин нэмэгдсэн бөгөөд тухайн машин нь элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн бөгөөд шинээр үнэ тогтоон данс бүртгэлд тусгасан байна. Шатахууны зардалд 18.1 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 6.1 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Чулуут сумын ЗДТГ нь 2021 онд 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чулуут сумын ЗДТГ нь 2021 онд 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 % буюу 12.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, эд хөрөнгийн үнийг зөвшилцөн тогтоох үед УСНББОУС 23 “Арилжааны бус орлого” гэсэн стандартын 42, 44 дүгээр параграфийн дагуу орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах, Төсвийн тухай хуулийн 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, УСНББОУС болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулахад анхаарч ажиллах зөвлөмжүүдийг хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16.8 сая төгрөгийн алдааг залруулж, 19.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдал 3.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 16.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Тус байгууллага нь 2021 онд 19.1 сая төгрөгийн авлагтай ажилласан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх заалтын дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, авлагыг бууруулан ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Чулуут сумын ЗДТГ	Тайлант онд 19.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн.	1	19.1							1	19.1
2		Үнэ төлбөргүй хүлээн авсан 16.8 сая төгрөгийн өвс тэжээлийг бүртгэл тайланд зөрүүтэй тусгасанг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлээ	1	16.8	1	16.8						
Дүн			2	35.9	1	16.8					1	19.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Чулуут сумын ЗДТГ	МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 10 % буюу 12.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна	1	12.3					1	12.3		
2		Шилэн дансны цахим хуудсанд 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1						1			
Дүн			2	12.3					2	12.3		
Нийт дүн			4	48.2	1	16.8			2	12.3	1	19.1